



СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Сэлэнгэ аймгийн Сант сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын хураангуй тайлан

Аудитын код: СЭА-2026/013/НА-СТА-ТТЗ

Цахим хуудас: www.selenge@audit.gov.mn Сүхбаатар сум 2026 он	Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор: Б.Батмөнх Утас: 7036-3040 Цахим хаяг: Batmunkhb@audit.gov.mn Ахлах аудитор: Ц.Отгонбаяр Утас: 7036-3036 Цахим хаяг: Otgonbayarts@audit.gov.mn Аудитор: Э.Энхбүрэн Утас: 7036-3036 Цахим хаяг: Enkhburene@audit.gov.mn
---	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

1. ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

II баг, Цагаан эрэг, Сүхбаатар сум,
Сэлэнгэ аймаг, 43081
Утас/Факс: (976)-7036-3040
Цахим шуудан: Selenge@audit.gov.mn
Цахим хуудас: www.audit.mn

САНТ СУМЫН ЗАСАГ ДАРГА
С.ШИЖИРБААТАР ТАНАА

2026.03.25 № СА-2026/013/НА-СТА-ТТЗ
танай _____-ны № _____-т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-т заасны дагуу Сэлэнгэ аймгийн Сант сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл **2,232,331.1** мянган төгрөг буюу **77.7** хувьтай байгаа нь бараа, ажил үйлчилгээний зардлыг 272,376.1 мянган төгрөгөөр, хөрөнгийн зардлыг 167,819.0 мянган төгрөгөөр, эргэж төлөгдөх зээлийг 195,001.9 мянган төгрөгөөр тус тус хэмнэснээс шалтгаалсан байна.

Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь

3

4326050367

харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Тайлант онд аймгийн ОНХС-гийн хөрөнгөөр 779,999.6 мянган төгрөгийн, сумын ОНХС-гийн хөрөнгөөр 450,091.7 мянган төгрөгийн нийт 1,230,091.2 мянган төгрөгийн дулааны шугам засвар, шинэчлэлийн ажил хийгдэж сумын төсөвт байгууллагууд 2025 оны намраас эхлэн нэгдсэн халаалтын системд холбогдсон байна.

Бусад асуудлын хэсэг

Сант сумын Засаг дарга нь тайлант онд 3 зорилт, 48 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, **91.2** хувийн хэрэгжилттэй тайлагнасан байна.

Санхүүгийн тайланд толилуулж, тодруулснаас бусад аудиторын шийдлээр онцлох асуудал байхгүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Б.БАТМӨНХ

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан

/мянган төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Тодруулга	2024 оны 12-р сарын 31	2025 оны 12-р сарын 31
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	4	577,159.4	766,456.6
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ		383,607.6	551,072.2
33	АВЛАГА		174,372.1	191,653.5
35	БАРАА МАТЕРИАЛ	6	19,179.7	23,730.9
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН		5,486,141.8	6,781,027.7
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	7	5,486,141.8	6,781,027.7
39200	Биет хөрөнгө		4,895,161.3	6,191,604.7
39300	Биет бус хөрөнгө		590,980.5	589,423.0
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН 3=1+2		6,063,301.1	7,547,484.3
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	9	42.5	16,044.2
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР		42.5	16,044.2
41300	Өглөг		42.5	16,044.2
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН		6,063,258.7	7,531,440.1
51	Засгийн газрын хувь оролцоо		6,063,258.7	7,531,440.1
51100	Засгийн газрын оруулсан капитал		627,122.1	627,122.1
51200	Хуримтлагдсан үр дүн		5,083,569.8	6,551,751.3
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү		352,566.8	352,566.8
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН 6=4+5		6,063,301.1	7,547,484.3

2.2 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан

/мянган төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Тодруулга	2024 оны 12-р сарын 31	2025 оны 12-р сарын 31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН	2	5,315,616.7	4,009,548.0
11	ТАТВАРЫН ОРЛОГО		545,647.7	612,911.8
110	Орлогын албан татвар		358,636.0	390,071.6
1100	Хувь хүний орлогын албан татвар		387,346.7	408,485.1
1101	Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт		(28,710.7)	(18,413.5)
113	Хөрөнгийн албан татвар		78,013.6	182,021.5
118	Бусад татвар, төлбөр, хураамж		108,998.1	40,818.7
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО		3,572,161.1	3,396,636.2
120	Нийтлэг татварын бус орлого		120,355.5	169,013.4
122	Тусламжийн орлого		-	1,262,466.6

123	Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг		-	364,794.0
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО		1,197,807.9	-
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого		44,155.8	-
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих		1,177,748.6	-
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	3	1,699,243.7	1,922,820.3
21	УРСГАЛ ЗАРДАЛ		1,699,243.7	1,922,820.3
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ		1,635,703.6	1,904,835.6
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил		741,520.8	867,082.2
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл		88,453.3	106,911.9
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал		395,070.0	420,274.1
2104	Хангамж, бараа материалын зардал		56,404.2	50,102.4
2106	Эд хогшил, урсгал засварын зардал		23,754.6	36,453.9
2107	Томилолт, зочны зардал		8,041.9	11,623.2
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж		7,150.3	10,515.1
2109	Бараа үйлчилгээний бусад зардал		315,308.5	401,872.9
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ		63,540.2	17,984.6
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг		-	-
2132	Бусад урсгал шилжүүлэг		63,540.2	17,984.6
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)		3,616,373.0	2,086,727.8
V	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН		401,880.5	618,546.3
VII	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (VII)=(IV)-(V)		(401,880.5)	(618,546.3)
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(VII)		3,214,492.5	1,468,181.5

2.4 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан

/мянган төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	2024 оны 12-р сарын 31	2025 оны 12-р сарын 31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН	1,887,907.6	2,405,932.8
11	ТАТВАРЫН ОРЛОГО	545,647.7	612,911.8
110	Орлогын албан татвар	358,636.0	390,071.6
1101	Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт	(28,710.7)	(18,413.5)
113	Хөрөнгийн албан татвар	78,013.6	182,021.5
118	Бусад татвар, төлбөр, хураамж	108,998.1	40,818.7

12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	120,355.5	1,793,020.9
120	Нийтлэг татварын бус орлого	120,355.5	169,013.4
122	Тусламжийн орлого	-	1,259,213.5
123	Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг	-	364,794.0
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,221,904.4	-
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,492,929.9	1,559,921.8
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,492,929.9	1,559,921.8
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,429,389.7	1,542,245.8
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	737,580.5	867,081.7
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	88,453.3	106,911.9
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	395,103.1	420,274.1
2104	Хангамж, бараа материалын зардал	46,664.4	48,117.6
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	29,365.5	37,022.9
2107	Томилолт, зочны зардал	8,041.9	11,353.2
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	7,150.3	9,602.1
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	117,030.8	41,882.3
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	63,540.2	17,676.0
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	394,977.7	846,010.9
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН	221,021.8	618,546.3
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	221,021.8	618,546.3
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	(221,021.8)	(618,546.3)
23	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	-	60,000.0
VII	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН	-	(60,000.0)
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	173,955.9	167,464.6
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	209,651.7	383,607.6
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	383,607.6	551,072.2

2.3 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/мянган төгрөгөөр/

Засгийн газрын хувь оролцоо	Засгийн газрын хувь оролцоо	Дахин үнэлгээний нөөц	Бусад цэвэр хөрөнгө /өмч	Хуримтлагдсан үр дүн	Хяналтын бус хувь оролцоо	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	627,122.1	352,566.8	-	1,869,077.3	-	2,848,766.1
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	627,122.1	352,566.8	-	1,869,077.3	-	2,848,766.1
Тайлант үеийн үр дүн	-	-	-	3,214,492.5	-	3,214,492.5
2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	627,122.1	352,566.8	-	5,083,569.8	-	6,063,258.7
2025 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	627,122.1	352,566.8	-	5,083,569.8	-	6,063,258.7
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	627,122.1	352,566.8	-	5,083,569.8	-	6,063,258.7
Тайлант үеийн үр дүн	-	-	-	1,468,181.5	-	1,468,181.5
2025 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	627,122.1	352,566.8	-	6,551,751.3	-	7,531,440.1

2.5 Аудит хийсэн нэгтгэсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/мянган төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
1	НИЙТ ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН	2,874,626.1	2,586,207.0	288,419.1	90.0%
11	Татварын орлого	607,904.1	612,911.8	(5,007.7)	100.8%
110	Орлогын албан татвар	361,605.8	390,071.6	(28,465.8)	107.9%
1100	Хувь хүний орлогын албан татвар	390,316.5	408,485.1	(18,168.6)	104.7%
1101	Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт	(28,710.7)	(18,413.5)	(10,297.2)	64.1%
113	Хөрөнгийн албан татвар	118,418.6	182,021.5	(63,602.9)	153.7%
118	Бусад татвар, төлбөр, хураамж	127,879.7	40,818.7	87,061.0	31.9%
12	Татварын бус орлого	3,837,063.0	3,499,057.3	338,005.7	91.2%
120	Нийтлэг татварын бус орлого	283,650.5	165,760.3	117,890.2	58.4%
122	Тусламжийн орлого-Эхний үлдэгдэл	366,270.3	190,733.6	175,536.7	52.1%
123	Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг	364,794.0	364,794.0	-	100.0%
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	2,874,626.1	2,232,331.1	642,295.0	77.7%
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,833,258.9	2,232,331.1	(399,072.2)	121.8%
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,808,484.8	1,536,108.7	272,376.1	84.9%
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	984,990.5	866,567.2	118,423.3	88.0%

2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	129,497.1	106,852.7	22,644.4	82.5%
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	439,006.1	420,274.1	18,732.0	95.7%
2104	Хангамж, бараа материалын зардал	67,274.2	46,553.0	20,721.2	69.2%
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	56,469.9	37,022.9	19,447.0	65.6%
2107	Томилолт, зочны зардал	17,000.0	11,353.2	5,646.8	66.8%
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	33,617.3	9,602.1	24,015.2	28.6%
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	80,629.7	37,883.6	42,746.1	47.0%
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	24,774.1	17,676.0	7,098.1	71.3%
2132	Бусад урсгал шилжүүлэг	24,774.1	17,676.0	7,098.1	71.3%
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	786,365.3	618,546.3	167,819.0	78.7%
23	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	255,001.9	60,000.0	195,001.9	23.5%
8	ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН НИЙТ ТЭНЦЭЛ	-	(163,142.3)	163,142.3	
9	АЛДАГДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	-	(163,142.3)	163,142.3	
7	Харилцах болон хадгаламжийн дансны цэвэр өөрчлөлт	-	(163,142.3)	163,142.3	
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	383,607.6	(383,607.6)	
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	551,072.2	(551,072.2)	
6	ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ	53	49	4	81.1%
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	1	1	-	100.0%
610001	Төсвийн байгууллага	1	1	-	100.0%
62	АЖИЛЛАГСДЫН ТОО	26	24	2	80.8%
620001	Удирдах ажилтан	7	7	-	71.4%
620002	Гүйцэтгэх ажилтан	14	12	2	78.6%
620003	Үйлчлэх ажилтан	1	1	-	100.0%
620004	Гэрээт ажилтан	4	4	-	100.0%
65	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	26	24	2	80.8%
650001	Төрийн захиргааны албан хаагч (ТЗ)	11	10	1	72.7%
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	10	9	1	90.0%
650011	Улс төрийн албан хаагч (УТ)	5	5	-	80.0%

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

/мянган төгрөгөөр/

Дансны код	Дансны нэр, төрөл	Тайлант он
1	НИЙТ ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН	7,206.3
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	7,206.3
122	Тусламжийн орлого	7,206.3
1221	Хандив тусламж /дотоод/	7,206.3

12213	Нэмэлт санхүүжилтийн орлого	7,206.3
350013	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	4,000.0
350014	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	3,206.3
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	6,137.1
21	УРСГАЛ ЗАРДАЛ	6,137.1
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	6,137.1
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	514.5
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	59.2
2104	Хангамж, бараа материалын зардал	1,564.6
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	3,998.8
4	ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН НИЙТ ТЭНЦЭЛ	1,069.2
5	АЛДАГДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	(1,069.2)
6	Харилцах болон хадгаламжийн дансны цэвэр өөрчлөлт	(1,069.2)

3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт **1286.1** мянган төгрөгийн алдаа¹ илэрснийг аудитын явцад залруулсан.

Залруулсан алдаа:

- ХХС: Хугацаа хэтэрсэн зээлийн 273.8 мянган төгрөгийн алдангийг дутуу тооцоолж бүртгэсэн,
- ХХС: Хоршоо хөгжүүлэх сангийн зээл олголтын программ дахь үлдэгдлийг тайланд 1,012.3 мянган төгрөгийн зөрүүтэй илэрхийлсэн. .

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1 дэх “*Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно*” гэсэн заалт болон УСНББОУС-1 “*Санхүүгийн тайлангийн толилуулга агуулга*”-ийн 27-д “*Санхүүгийн тайланд байгууллагын санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээг үнэн зөв толилуулах ёстой...*”, санхүүгийн тайлангийн “*Үнэлгээ ба хуваарилалт*” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

Аудитаар нийт **422,519.7** мянган төгрөгийн зөрчил² илэрснээс **815.0** мянган төгрөгийн 2 төлбөрийн акт, **8,835.6** мянган төгрөгийн 2 албан шаардлага, **412,869.1** мянган төгрөгийн зөвлөмж өгөв.

Нийт илрүүлсэн алдаа, зөрчлөөс **8,835.6** мянган төгрөгийн залруулагдаагүй материаллаг зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс **8,156.8** мянган төгрөгөөр бага тул **Өөрчлөлтгүй** дүгнэлт өглөө.

5.1 Төлбөрийн акт

5.1.1. Тайлант онд ЗДТГ нь 19 албан хаагчид 725.0 мянган төгрөгийн, ИТХ нь 3 албан хаагчид 90.0 мянган төгрөгийн нийт 815.0 мянган төгрөгийн хоолны хөнгөлөлтийг албан томилолтой давхардуулан тооцож, олгосон зөрчил илэрлээ.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 дэх “*Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах*”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5 дахь “*Ерөнхий нягтлан бодогч дараах үүрэг хүлээнэ: дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах*” гэсэн заалтуудыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Илүү олгосон хоолны мөнгийг нөхөн төлүүлэх төлбөрийн акт тогтоов.

5.2 Албан шаардлага:

5.2.1 ЗДТГ нь 2025 оны жилийн эцсийн тооллогоор бодитоор оршин байхгүй 7 ширхэг хувцасны шүүгээ, 20 ширхэг ширээ нийт **2,750.0** мянган төгрөгийн хөрөнгийг бүртгэл тайланд тусгасан зөрчил илэрлээ.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1 дэх “*Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн зөв гаргах үндэслэл болно*”, 20 дугаар зүйлийн 20.2.6 дахь “*Эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах*” гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Бодитоор оршин байхгүй хөрөнгийн шалтгааныг тогтоож, дутагдлыг арилгах арга хэмжээг авах албан шаардлага хүргүүлэв.

5.2.2 ОНЕО-ын дансанд бүртгэлтэй 2010-2011 онд 5 иргэнд олгосон **6,085.6** мянган төгрөгийн итгэлийн зээлийг барагдуулах талаар одоог хүртэл арга хэмжээ авч ажиллаагүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5 дахь “*дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах*”, 20.2.6 дахь “*Эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан*

² Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах”, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын 2021 оны А/361 дүгээр тушаалын хавсралтаар батлагдсан "Хоршоог хөгжүүлэх сангаас хөнгөлөлттэй зээл олгох, сонгон шалгаруулах, эргэн төлүүлэх, хяналт тавих журам"-ын 10.5 дахь “Зээлдэгчийн гэрээнд эрсдэл үүссэн тохиолдолд зээлийн хөрөнгийг эргүүлэн татах ажиллагааг сумын Засаг дарга болон хяналтын зөвлөл хариуцан зохион байгуулна. Энэхүү зохицуулалтыг зээлийн гэрээгээр нарийвчлан зохицуулна” гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Зээлийг эргэн төлүүлж, авлагыг барагдуулах албан шаардлага хүргүүлэв.

5.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

5.3.1 Үндсэн хөрөнгийн ашиглалттай холбоотой

1.1 Илрүүлэлт: ЗДТГ нь үндсэн хөрөнгийн дансанд бүртгэлтэй ашиглалтын хугацаа дуусаж, элэгдлээрээ анхны өртгөө бүрэн нөхсөн боловч ашиглагдаж байгаа нийт 25,585.2 мянган төгрөгийн анхны үнэтэй 14 нэр төрлийн хөрөнгө, аймгийн ИТХ-с шилжиж ирсэн элэгдлээ бүрэн байгуулсан 111,800.0 мянган төгрөгийн үнэ бүхий Лексус-570 автомашиныг шилжүүлэн авахдаа ӨХЗ-р дахин үнэлж бүртгээгүй, шинэчлэн тогтоох саналыг эрх бүхий байгууллага, албан тушаалтанд тавьж шийдвэрлүүлээгүй байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.2-т “илүүдэл эд хөрөнгө болон элэгдэл хорогдлын шимтгэлээр анхны үнийг нь нөхсөн, түүнчлэн нөхөөгүй боловч гэмтэж, засаж сэлбээд өөр зориулалтаар ашиглаж болох эд хөрөнгийн үнийг төрийн өмчийн бодлого, зохицуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагатай зөвшилцөн тогтоох” гэсэн заалтыг зөрчсөн бөгөөд УСНББОУС-17 стандарт болон “Үнэлгээ ба хуваарилалт” батламж мэдэгдлийг хангаагүй байна.

1.2 Өгсөн зөвлөмж: Элэгдлээрээ анхны өртгөө бүрэн нөхсөн, цаашид ашиглах боломжгүй үндсэн хөрөнгүүдийг холбогдох байгууллагад уламжилж, данс бүртгэлээс хасах болон ашиглах боломжтойг дахин үнэлж бүртгэх

2.1 Илрүүлэлт: ЗДТГ нь ХХААЯ-аас шилжүүлэн өгсөн 2 ширхэг тракторын дагалдах хэрэгсэл, 1 ширхэг бага оврын экскаваторыг холбогдох анхан шатны баримт байхгүй шалтгаанаар бүртгэлд тусгаагүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.1 дэх “Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно”, 14.4 дэх “Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ”, 14.4.2 “бүх хөрөнгө, хөрөнгө оруулалт, авлага”, гэсэн заалт, УСНББОУС-17 стандарт болон “Иж бүрэн байх” батламж мэдэгдлийг хангаагүй байна.

2.2 Өгсөн зөвлөмж: Бүртгэлгүй хөрөнгийг холбогдох анхан шатны баримтыг бүрдүүлсний үндсэн дээр орлогод авах

3.1 Илрүүлэлт: ЗДТГ нь 2018 онд худалдан авч тус ондоо эвдэрсэн 26,200.0 мянган төгрөгийн үнэ бүхий дугуйт ачигч/ковш/-ийг өмч хамгаалах зөвлөлийн хурлаар хэлэлцэж, засуулах арга хэмжээ аваагүйгээс өдийг хүртэл ашиглагдаагүй байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.1 дэх "Өөрт олгогдсон эд хөрөнгийн бүрэн бүтэн байдлыг хангаж, үйл ажиллагааныхаа зорилгод нийцүүлэн зориулалтын дагуу эзэмшиж, ашиглах" гэсэн заалтыг зөрчсөн бөгөөд УСНББОУС-1 стандарт болон "Нийцсэн бөгөөд зохистой байх" батламж мэдэгдлийг хангаагүй байна.

3.2 Өгсөн зөвлөмж: Ашиглалтгүй хөрөнгийг засуулах арга хэмжээ авч зориулалтын дагуу ашиглах.

5.3.2 Авлагатай холбоотой асуудал:

1.1 Илрүүлэлт: ХХС-аас олгосон нийт зээлийн 9 иргэний 131,891.0 мянган төгрөгийн буюу 66.2 хувь нь хугацаа хэтэрсэн болон хэвийн бус, 6.7 хувь нь чанаргүй ангилалд шилжсэн буюу зээл, зээлийн хүү, алдангийг барагдуулах арга хэмжээ хангалтгүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5 дахь "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах", Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын 2021 оны А/361 дүгээр тушаалын хавсралтаар батлагдсан "Хоршоог хөгжүүлэх сангаас хөнгөлөлттэй зээл олгох, сонгон шалгаруулах, эргэн төлүүлэх, хяналт тавих журам"-ын 10.5 дахь "Зээлдэгчийн гэрээнд эрсдэл үүссэн тохиолдолд зээлийн хөрөнгийг эргүүлэн татах ажиллагааг сумын Засаг дарга болон хяналтын зөвлөл хариуцан зохион байгуулна. Энэхүү зохицуулалтыг зээлийн гэрээгээр нарийвчлан зохицуулна" гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн бөгөөд УСНББОУС-1 стандарт болон санхүүгийн тайлангийн "Нийцсэн бөгөөд зохистой байх" батламж мэдэгдлийг хангаагүй байна.

1.2. Өгсөн зөвлөмж: Чанаргүй зээлийн үлдэгдлийг бууруулах шат дараалсан арга хэмжээг авч ажиллах.

5.3.3 Орон нутгийн хөгжлийн сангийн бүртгэл мэдээлэлтэй холбоотой:

1.1 Илрүүлэлт: ОНХС-аас хэрэгжүүлсэн 618,546.3 мянган төгрөгийн 16 төсөл арга хэмжээнээс удирдлага мэдээллийн системд 11 төсөл арга хэмжээний 112,521.6 мянган төгрөгийн төсөл арга хэмжээний мэдээллийг дутуу оруулсан нь ОНХС-ийн үйл ажиллагааны журмын 10.3.2 дэх "Аймаг, нийслэл, сум, дүүргийн ОНХС хариуцсан мэргэжилтэн ОНХС-ийн УМС-ийн хэрэгжилт цэсэд хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээний хэрэгжилтийн талаарх мэдээллийг ОНХС-ийн УМС-д оруулж, оруулсан мэдээллийн дагуу санхүүжилтийг хийнэ" гэсэн заалтыг зөрчсөн бөгөөд УСНББОУС-1 стандарт болон "Нийцсэн бөгөөд зохистой байх" батламж мэдэгдлийг хангаагүй байна.

1.2 Өгсөн зөвлөмж: ОНХС-ийн төсөл арга хэмжээг удирдлага мэдээллийн системд тухай бүр бүртгэж байх

5.3.4 Цалин хөлстэй холбоотой:

1.1 Илрүүлэлт: ЗДТГ болон ИТХ нь 3 албан хаагчийн цалингаас нийт 3,421.3 мянган төгрөгийн байрны түрээсийг суутган тооцож олгосон байна. Энэ нь Хөдөлмөрийн тухай хуулийн 119 дүгээр зүйлийн “Цалин хөлснөөс хийх суутгал, түүний хэмжээг хязгаарлах”, 119.1.4 дэх “хууль тогтоомжид заасан бусад тохиолдол” гэсэн заалтыг зөрчсөн бөгөөд санхүүгийн тайлангийн “Нийцсэн бөгөөд зохистой байх” батламж мэдэгдлийг хангаагүй байна.

1.2 Өгсөн зөвлөмж: Цаашид албан хаагчдын цалингаас хууль тогтоомжид зааснаас бусад суутгалыг суутгахгүй байх зөвлөмж өгөв.

5.3.5. Шатахууны зарцуулалттай холбоотой:

Илрүүлэлт: ЗДТГ нь 1,100.0 мянган төгрөгийн шатахууныг, ИТХ нь 350.0 мянган төгрөгийн шатахууныг анхан шатны баримтын бүрдүүлбэр дутуу буюу замын хуудсанд ирсэн явсан км, норм, зарцуулсан шатахууныг тэмдэглээгүй, 100 км-т зарцуулах шатахууны нормыг хэтрүүлэн олгосон байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1 дэх “Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн зөв гаргах үндэслэл болно”, 13.7 дахь “Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно”, 20 дугаар зүйлийн 20.2.5 дахь “дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах”, Зам, тээврийн хөгжлийн сайдын 2019 390 дугаар тушаалын 1 дүгээр хавсралт “Автомашинны 100 км гүйлтэд зарцуулах шатахуун зарцуулалтын жишиг норм” гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн бөгөөд УСНББОУС-12 стандарт болон “Нийцсэн бөгөөд зохистой байх” батламж мэдэгдлийг хангаагүй байна.

Өгсөн зөвлөмж: Автомашинны шатахууныг батлагдсан нормын дагуу олгох, зарцуулалтад хяналт тавих

Дээрх зөвлөмжүүдийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг Төрийн аудитын тухай хуулийн 20.5³ дахь заалтад тусгасны дагуу аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор, биелэлтийг 2026 оны 09 дүгээр сарын 15-ны өдрийн дотор тус тус төрийн аудитын байгууллагад ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

³ Шалгагдагч этгээд болон холбогдох бусад албан тушаалтан нь энэ хуулийн 20.2-т заасан зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор төрийн аудитын байгууллагад ирүүлнэ.

4. АУДИТААР ИЛЭРСЭН АЛДАА, ЗӨРЧЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Байгууллагын нэр	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
ХХС	2	1,286.1	2	1,286.1			2	1,286.1				
Дүн	2	1,286.1	2	1,286.1			2	1,286.1				

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Байгууллагын нэр	Нийт зөрчил		Үүнээс										
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	
ТТЗ	1	6,085.6			1	6,085.6							
ЗДТГ	7		1	725.0	1	2,750.0	5	166,525.7					
ИТХ	3	680.7	1	90.0			2	1,930.8					
ХХС	1	-					1	131,891.0					
ОНХС	1	-					1	112,521.6					
Дүн	13	422,519.7	2	815.0	2	8,835.6	9	412,869.1					

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Байгууллагын нэр	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Төсвийн төвлөрүүлэн захирагч 8 мэдээлэл, Иргэдийн төлөөлөгчдийн хурал 9 мэдээлэл, Засаг даргын тамгын газар 9, Орон нутгийн хөгжлийн сан 15 мэдээлэл, Хоршоог хөгжүүлэх сан 7 мэдээлэл зэрэг нийт 48 мэдээллийг хугацаа хоцроон мэдээлсэн.							1	-
Дүн								
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
ТБОНӨХБАҮХАТ хуулийн хэрэгжилттэй холбоотой								
Урьдчилгаа төлбөрийн баталгаагүйгээр урьдчилгаа санхүүжилт олгосон.								
Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой								
Нийт дүн								